



**МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/191

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” 124 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Мөрөн сумын 39.3 авто замын халтиргаа гулгаа аюулгүй байдлыг хангах арчлахад шаардагдах замын тусгай зориулалтын давс /Багц-1/ нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202312050 дугаартай тендерт 9,270,000 (Есөн сая хоёр зуун далан мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Эрчимт Өрнөл” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Эрчимт Өрнөл” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн (Ё.Батсайхан)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Ажлын хэсгийн гишүүд: Г.Нандин-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн тооцооны нягтлан бодогч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Л.Болор-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн зам талбай хариуцсан мэргэжилтэн)


3. Мөрөн сумын 39.3 авто замын халтиргаа гулгаа аюулгүй байдлыг хангах арчлахад шаардагдах замын тусгай зориулалтын давс /Багц-1/ нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Ё.Батсайхан)-д, захиалагч, тендерт

d/A4

671010062

оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Минжүүржаргал)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ШИДЭРБАЯСГАЛАН